

## **СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2014 ОНЫ 12 ДУГААР САРЫН МЭДЭЭ**

### **Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:**

#### **1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:**

Аймгийн ИТХ-ын Төлөөлөгчдийн ээлжит бус XI хуралдаан хуралдаж 1 асуудал хэлэлцэн 1 тогтоол баталсан байна. Үүнд:

1.Монгол Улсын Их Хурал 2014 оын төсөвт тодотгол хийсэнтэй холбогдуулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрээр ээлжит бус 11-р хуралдааныг зарлан хуралдуулж аймгийн 2014 оны төсвийг тодотгон баталлаа. Тус хуралдаанаар сумдын ОНХС-ийн хөрөнгийн хуваарьт өөрчлөлт оруулж аймгийн 2014 оын төсвийг 67 890 210.3 мянган төгрөгөөр тодотгож баталлаа.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид 12 дугаар сард 2 удаа хуралдаж 12 асуудал хэлэлцэн 11 тогтоол баталсан байна. Үүнд:

1.УИХ-аас Монгол Улсын 2014 оны төсөвт тодотгол хийсэнтэй холбогдуулан аймгийн ИТХ-ын ээлжит бус 11-р хуралдааныг зарлалаа.

2.Аймгийн хэмжээнд 2015 онд үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалттай хэрэглээний мод, түлээ бэлтгэх хуваарийг баталлаа.

3.Нутаг дэвсгэр хариуцсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий орон тооны бус Иргэний зөвлөлийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэд байгуулан дарга, гишүүдийг томиллоо.

4.Сүхбаатар сумын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа Буддын шашны “Хутагт эх” хийдийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хугацааг 2 жилийн хугацаагаар сунгалаа.

5.Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй томоохон аж ахуй нэгжүүдтэй нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэх чиглэлээр нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран ажиллах гэрээний төсөлд тусгах асуудлын талаар хэлэлцээр хийх ажлын хэсэг, ажиллах удирдамжийг баталлаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар хөдөлмөр бүтээл, авъяас билэг, ур чадвараараа бусдыгаа манлайлсан 65 иргэнийг гарган Хөдөлмөрийн гавъяаны улаан туг, Алтангадас одон, Хөдөлмөрийн хүндэт медаль, Шудрага журам зэрэг төрийн дээд одон медалиудаар шагнаж урамшуулсан иргэдэд шагнал гардуулах ажиллагааг зохион байгууллаа.

#### **2.Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:**

Төсвийн тухай хуулийн хэрэгжилт, улсын болон орон нутгийн төсвийн зарцуулалт, түүнд тавих хяналтыг сайжруулах, орон нутгийн төсөв санхүүгийн бодлого, төлөвлөлт, цаашид анхаарах асуудлуудын талаар нэгдсэн ойлголт өгөх, харилцан мэдээлэл солилцох зорилготой “Орон нутгийн төсөв, санхүүгийн өнөөгийн байдал, цаашид анхаарах асуудлууд” сэдэвт зөвлөгөөнийг аймгийн Засаг даргын Тамгын газар, Аудитын газартай хамтран зохион байгууллаа. Зөвлөгөөнд бүх сумдын Засаг дарга, ерөнхий нягтлан бодогч, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн захирал, эрхлэгч нарын 230 гаруй төлөөлөл оролцлоо.

Сурагчдыг болзошгүй осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, сургалтын таатай орчинг бүрдүүлэх зорилгоор аймгийнхаа сургуулиудыг автобусаар хангах арга хэмжээг зохион байгуулж, аймгийн 32 сургуулийн 24-т нь БНСУ-д үйлдвэрлэгдсэн “Starix” маркын бага оврын автобус олголоо.

Сэлэнгийн тариаланчид тариалсан улаанбуудайн нэг га тутмаасаа 17.6 цн ургац хураан авсаны дотор Хушаат сумын “Момо-Агро” ХХК 67 га талбайгаас 426 тн буюу нэгж га-гаас 63.7 цн улаанбуудай хурааж сүүлийн 26 жилд давтагдаагүй шинэ дээд амжилт тогтоон атар газар эзэмшсэнийхээ 55 жил, “Сэлэнгэ-Ургац-2014” баяраа тэмдэглэн өнгөрүүллээ. Баярын арга хэмжээний үеэр алтан намрын 9 шилдгийг тодруулж, алтан түрүүний эзэд боллоо. Энэ жил 245000 тн үр тариа үүний дотор 230000 тн улаанбуудай, 20600 тн тосны ургамал, 46074 тн төмс, 31475 тн хүнсний ногоо, 174600 тн жимс, жимсгэнэ хураан авсан дүнтэй байна. Мөн “Сэлэнгийн Ургац-2014” баярын арга хэмжээний хүрээнд тариаланчдын өмнө тулгараад байгаа хамгийн гол асуудал болсон хөрсний үржил шимийн асуудлаар аймгийн ҮХААГ-аас хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Монголын Хүний эрхийн Үндэсний комиссоос орон нутгийн сэтгүүлчдэд зориулсан “Хэвлэл мэдээлэл ба хүний эрх” сэдэвт сургалтыг зохион байгуулж, “Хүний эрхийн Үндэсний комиссын үйл ажиллагаа орон нутаг”, “Хүний эрхийн тухай үндсэн ойлголт”, “Нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэхдээ анхаарах хүний эрхийн зарим асуудал”, “Хүний эрхэд суурилсан хандлага” сэдвүүдээр мэдээлэл хийж, харилцан ярилцлаа. Сургалтанд аймгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудын удирдлага, ажилтан, сэтгүүлч, сурвалжлагч болон байгууллагуудын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажилтнууд оролцсон.

Үндэсний сурын спортыг хойч үедээ өвлүүлэн үлдээх, хөгжүүлэх, онолын мэдлэг олгох, сумдын сурын товчоодын ажиллах чиг үүргийг тодорхой болгох зорилгоор Сэлэнгэ аймгийн “Үндэсний сурын харвааг хөгжүүлэе” зөвлөгөөнийг энэ сарын 18-ны өдөр зохион байгууллаа. Зөвлөгөөнд сумдын Засаг даргын Тамгын газрын дарга, Соёлын төвийн эрхлэгч, биеийн тамирын багш нар, харваачид оролцож, “Нум сумын үүсэл, зэр зэвсэгийн тухай”, “Монгол харвааны хөгжсөн үе шатууд”, “Үндэсний сурын уламжлалт харвааны тухай”, “Сэлэнгэ аймгийн үндэсний сурын товчоо, үүсэл, хөгжил, төрөн гарсан алдартнуудын тухай”, “Буриад сурын харвааны тухай, “Урианхай сурын харвааны тухай”, “Сэлэнгэ аймгийн үндэсний сурын харвааг хөгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө”-ний талаарх илтгэл мэдээллийг сонсож, харилцан ярилцлаа.

Аймгийн Засаг дарга энэ сарын 15,16-ны өдрүүдэд Сант, Орхон сумдад ажиллаж өвөлжилтийн бэлтгэл ажилтай танилцан, ард иргэдтэй уулзалт зохион байгууллаа. Хавар, намрын ургац хураалтанд ашиглаж байгаа техник тоног төхөөрөмжүүдийн засварын иж бүрэн цех байгуулах, хоршооллыг ямар хэлбэрээр хэрхэн яаж байгуулах, орон сууцжуулалт, барилгажилтын асуудал зэрэг иргэдийн санал шүүмжлэлийг сонсож, зөвлөмж чиглэл өглөө. Мөн дээрх сумдад иргэдийн хүсэлтийн дагуу хүн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын баг, газрын кадастрын үйлчилгээг үзүүллээ.

2014 оны жилийн эцсийн мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн ээлжит тооллого явагдахтай холбогдуулан аймгийн Засаг даргын захирамжаар тооллогын аймгийн комиссыг томилж, тооллогыг зохион байгууллаа. Аймгийн Статистикийн хэлтсээс сумын төрийн санч, статистикч, хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтнүүдийг хамруулсан сургалтыг зохион байгуулж, “Хүн ам өрхийн мэдээллийн сан, мал тооллогын сан, газар тариалангийн мэдээллийн сан, тэдгээрийн хэрэглээ, уялдаа холбоо, цаашдын зорилт”, мал тооллогын арга зүй, программ ашиглалтын талаар мэдээлэл өгч, сургалт явууллаа.

Сүхбаатар суманд үйл ажиллагаа явуулж байгаа хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлчид хамтын сурвалжлагын хүрээнд аймгийн удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, харилцан ярилцлаа. 2014 онд хийсэн ажил үйлчилгээ, ололт амжилт, цаашид хийх ажлынхаа талаар аймгийн удирдлагууд мэдээлэл өгч, сэтгүүлчдийн асуултанд хариуллаа.

Аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтыг 2014 оны 12 дугаар сарын 11, 12-ны өдөр бүртгэж 15,16-ны өдрүүдэд зохион байгууллаа. Энэ удаагийн шалгалтанд 50 ажлын байр зарлагдсанаас дэс түшмэлийн 29, туслах түшмэлийн 21 албан тушаалд нийт 309 хүн бүртгүүлж, 298 хүн өрсөлдөж 76 хүн тэнцлээ. Бүртгүүлээгүй 21 ажлын байр байгаагийн 11 нь дэс түшмэлийн, 10 нь туслах түшмэлийн ажлын байр байна.

### **Бусад ажлын талаар:**

#### **1.Онцгой байдлын газар:**

Аймгийн Засаг даргын 2014 оны А/425-тоот захирамжаар Баруунбүрэн сумын гамшгаас хамгаалах команд штабын сургуулийг сумын Засаг дарга, Онцгой байдлын орон тооны бус штаб, мэргэжлийн анги, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын гамшгаас хамгаалах менежментийн мэдлэгийг дээшлүүлэх, ажлын уялдаа холбоог сайжруулах зорилгоор “Байгаль цаг агаарын аюулт үзэгдлийн хор уршгийг арилгах үеийн сумын Засаг дарга, томилгоот бие бүрэлдэхүүний харилцан ажиллагаа” сэдвийн хүрээнд 2014 оны 11 сарын 19-21-ны өдрүүдэд зохион байгууллаа. Сургуулийн ажиллагаанд сумын Засаг дарга, Онцгой комиссын гишүүд, Сумын орон тооны бус Онцгой байдлын штаб, сумын ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн томилгоот бүрэлдэхүүн, аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, нийт 94 хүн хамрагдсан.

#### **2.Стандартчилал хэмжил зүйн хэлтэс:**

Мандал, Сүхбаатар, Жавхлант, Түшиг, Хүдэр сумын 12 аж ахуйн нэгж байгууллагын худалдаа үйлчилгээний газруудад тохирлын үнэлгээ хийж, худалдаа, үйлчилгээний газрын мөрдвөл зохих стандартын 84,0-аас дээш хувийг хангасан 11 худалдаа, үйлчилгээний газарт тохирлын гэрчилгээ олгосон.

Сүхбаатар сумын 1 аж ахуйн нэгж иргэний 1 нэрийн 1 бүтээгдэхүүнийг сайн дурын баталгаажуулалтанд хамруулж, итгэмжлэгдсэн лабораторийн сорилт, шинжилгээний дүнг үндэслэн шинжээчийн дүгнэлт гаргаж, Сүхбаатар сумын иргэн Б.Баяржаргалын үйлдвэрлэдэг тахианы түүхий өндөг, “Өсөх” хэрчсэн гуриллын цехийн бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээ олгов. Мандал сумын иргэн Д.Равдандашийн үйлдвэрлэж буй хатаасан цоохор майлзны байгууллагын стандартын төсөлд шүүлт хийж, холбогдох аргазүйн зөвлөмж өгч засварлуулан стандартыг бүртгэж дугаар олголоо.

Стандартын салбар сангаас 6 аж ахуй нэгж, иргэний хүсэлтийн дагуу 5 нэрийн 6 стандартаар хангаж, арга зүйн зөвөлгөө өгч, 5 нэр төрлийн 5 стандартаар үйлчилгээ үзүүлсэн байна.

Сүхбаатар сумын худалдаа үйлчилгээнд ашиглаж байгаа 73 жинг баталгаажуулав.

Айл өрх, аж, ахуй нэгж, байгууллагын төлбөрийн тооцоонд ашиглагдаж байгаа 1 фазын 19 ш цахилгаан тоолуурыг баталгаажуулалтанд хамруулж, мөн 2 иргэний тоолуур гацсан эргэхгүй байна гэсэн гомдлыг барагдуулж ажиллалаа. Эзлэхүүн хэмжлийн төрлөөр 2 ШТС-ын 9 шатахуун түгээгүүрийн шингэн

хэмжигчийг баталгаажуулж, 2 нөөцлөх саванд онооллын хүснэгт зохион баталгаажуулж, 6 шатахуун нөөцлөх савны хэмжилт авч, ломбардны 1 жин баталгаажуулав.

**Хоёр.Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:**

**1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:**

11-р сарын 30-ний байдлаар /мянган төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Орон нутгийн төсвийн нийт орлого	14442445,2	14010672,0	97,0
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	11863567,8	11240931,4	94,8
2	Орон нутгийн төсвийн нийт зарлага	66953085,1	58032907,3	86,7
	Үүнээс: Аймгийн төсвийн зарлагын дүн	19999717,9	15375011,4	80,1
	- Аймгийн ОНХСангийн зарцуулалт	4013570,7	2683802,4	66,9
3	Улсын төсвөөс олгосон ОНХСангийн орлогын шилжүүлэг	819495,8	648918,4	79,2
4	Улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг	9865809,6	5889941,6	59,7
5	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	5822706,8	5841543,0	100,3
7	Засаг даргын нөөц	558360,0	477633,0	85,5

2014 оны төсвийн гүйцэтгэлийн 11 сарын мэдээгээр орон нутгийн төсвийн орлого 97,0 хувь, улсаасавах санхүүгийн дэмжлэг 100,0 хувь, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 59,7 хувь, салбарын байгууллагуудын тусгай зориулалтын шилжүүлэг 98,3 хувь тус тус биелэгдсэн байна. Төсвийн зарлагын гүйцэтгэл 86,7 хувийн биелэлттэй байна. Аймгаас олгох сумдын санхүүгийн дэмжлэг 100,3 хувь, Засаг даргаас олгох нөөц хөрөнгийн гүйцэтгэл 85,5 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

**2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:**

№	Барааны нэр, төрөл	Хэмжих нэгж	Үнэ, ханш /төгрөгөөр/	
			2014 оны 11-р сар	2014 оны 12-р сар
Нэг.Талх, гурил, будаа				
1	Гурил /1-гурил/	1 кг	1200	1100-1200
2	Талх /орон нутгийн/ том, жижиг	ш	1000, 2200	1000, 2200
3	Нарийн боов	1 кг	1900-2500	1900-2500
4	Элсэн чихэр	1 кг	1800-2100	1800-2100
5	Цагаан будаа	1 кг	2200-2400	2200-2400

Хоёр.Мах, махан бүтээгдэхүүн				
6	Хонины мах	1 кг	6500	6700
7	Үхрийн мах	1 кг	7500	7200
8	Адууны мах	1 кг	6000	6000
9	Ямааны мах	1 кг	5800	5800
10	Дотор мах цувдай	1 кг	4000	4000
11	Хиам, чанасан	1 кг	9000	9000
12	Гахайн мах	1кг	6000	6500
Гурав.Сүүн бүтээгдэхүүн				
12	Сүү /задгай/	1л	1000	1200
13	Сүү /савласан/	1л	2500	2500
14	Тараг /задгай/	1л	1100	1500
15	Хорхой ааруул	1 кг	10000	10000
16	Айраг	1л	-	-
17	Хуурай сүү /орос/	1 кг	4000	4000
18	Өндөг	ш	350	330
Дөрөв. Бүх төрлийн өөх тос				
19	Ургамлын тос	1 кг	2900-3300	2900-3300
20	Өөхөн тос	1 кг	1500	1500
21	Шар тос	1 кг	8000	8000
22	Масло /задгай/	1 кг	3200	3200
Тав.Хүнсний ногоо				
23	Төмс	1 кг	800	1500
24	Лууван	1 кг	800	1000
25	Манжин	1 кг	800	800
26	Байцаа	1 кг	700	1000
27	Сонгино	1 кг	1000-1500	1500-2000
28	Өргөст хэмх	1 кг	-	-
29	Тарвас /Монгол/	1 кг	-	-
30	Өргөст хэмх /даршилсан/	ш	3500	3500
31	Алаг салат /даршилсан/	ш	1900-2500	1900-2500
Зургаа.Тээвэр шатахуун				
32	Бензин А-80	1 л	1590	1590
33	Бензин А-92	1 л	1690	1690
34	Дизель түлш	1 л	1830	1830

### **Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:**

#### **1. Хууль эрх зүйн чиглэлээр:**

2014 оны аймгийн ИТХ-ын IX дүгээр хуралдаанаар Хүний эрх, эрх чөлөөг хангах ажлын хүрээнд “Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийг аймгийн хэмжээнд 2010-2014 онд 113 ажил арга хэмжээтэйгээр төлөвлөн 96,7 хувийн биелэлттэй хэрэгжүүлэн тайлагнасан. Хүний эрх, эрх чөлөөг хангах “Хүний эрхийг

хангах үндэсний хөтөлбөр”-ийг 2015-2018 оны төлөвлөгөөг 21 зорилтын 126 ажил арга хэмжээтэйгээр төлөвлөн аймгийн ИТХ-ын 2014 оны IX хуралдаанаар батлуулж хэрэгжилтийг эхлүүлээд байна.

Хүн амын төвлөрөл ихтэй Сүхбаатар, Мандал, Сайхан, Хушаат зэрэг сумдад “Хувийн өмчийн газрыг дайчлан авахтай холбоотой Үндсэн хуулийн эрх зүйн зохицуулалт” сэдэвт иргэдэд зориулсан сургалт зохион байгуулагдлаа.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар аймгийн “Иргэний зөвлөл”-ийг байгуулж, үйл ажиллагааг эхлүүлсэн.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, Иргэний зөвлөл, аймгийн Цагдаагийн газартай хамтран иргэд, цагдаагийн алба хаагчид оролцсон “Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа” зөвлөгөөнийг аймгийн Цагдаагийн газарт зохион байгуулсан.

Мандал, Сайхан суманд эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн онлайн үйлчилгээг шинээр анх бий болгосноор бүсийн сумдын иргэдэд эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйлчилгээг үзүүлэхэд ойр дөхөм боллоо.

Сумдын Засаг даргын Тамгын газраас 2014 онд зохион байгуулсан хууль эрх зүйн ажлын жилийн эцсийн тайлан, мэдээнүүдийг авч нэгтгэх ажлыг хийж байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн 2014 оны үйл ажиллагааны жилийн эцсийн тайлан мэдээг шинэчилсэн тайлангийн журмын дагуу гарган, баталгаажуулж Хууль зүйн яаманд хүргүүлсэн.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтэс, аймгийн Цагдаагийн газар, Хүчирхийллийн эсрэг үндэсний төвүүд хамтран аймгийн Цагдаагийн алба хаагч, сумдын Засаг даргын Тамгын газрын нийгмийн ажилтнуудыг хамруулсан 2 өдрийн сургалтыг аймгийн төвд зохион байгуулсан.

Авлига, ашиг сонирхлын зөрчил, ёс суртахууны чиглэлээр аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын ажилтнуудад сургалт зохион байгуулсан.

## **2.Архивын талаар:**

Хөдөлмөрийн хэлтэс болон аймгийн нэгдсэн Музейн архив, бичиг хэрэг хариуцсан ажилтнуудад ХХНЖ боловсруулах, байнга, түр, 70 жил хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл хөтлөх арга зүй болон төрийн архивт байгууллагад хадгалах хугацаа дууссан байнга хадгалах баримтыг цаасан болон цахим хэлбэрээр шилжүүлэх талаар заавар, зөвлөгөө өгсөн.

Байгууллагын архив, бичиг хэргийн ажилтнуудад зориулсан “Архивын ажлын талаарх гарын авлага”-ын эхийг бэлтгэлээ.

Шинээр байригдсан барилга байгууламжийн зураг төслийн баримтаар нөхөн бүрдүүлэлт хийх ажлын хүрээнд Ерөө сумын Бугант тосгоны захирагчийн албаны барилга угсралтын ажлын баримт бичиг, Шаамар сумын “Залуус хаус” хорооллын гүний худгийн барилгын ажлын зургийг хүлээн авч заавар журмын дагуу хүлээн авч хөмрөгт байрлуулсан.

Төрийн архивын AMS программд аймгийн Холбооны газар болон Усан замын тээврийн захиргааны 5867 хуудас баримтын 6180 заалт, хүний нэр 18674, газар зүйн нэр 2178, байгууллагын нэр 792-ийг тодорхойлон бичсэн.

Мастер хувиас Photoshop программ ашиглан аймгийн Холбооны газар, Усан замын тээврийн захиргааны 47 ХН-ний 6586 хуудсаар ашиглалтын хувь үүсгэж,

иргэд, албан байгууллагын хүсэлтийн дагуу архивын хуулбар 231, тодорхойлолт, магадлагаа 31 гаргаж үйлчилсэн.

### **Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:**

#### **1. Эрүүл мэндийн талаар:**

Эх, хүүхдэд үзүүлж буй тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор Эрүүл мэндийн Яам, Эх, хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний төвтэй хамтран аймгийн төв, сумдын эмнэлгүүдийн дарга, нэгдсэн эмнэлгийн эх барих, эмэгтэйчүүд, хүүхэд, нярайн эмч нарыг оролцуулсан ижил ажил мэргэжилтний туршлага солилцох “Жирэмсэн болон төрсний дараах үед эх, нярайд үзүүлэх тусламж үйлчилгээ”сэдэвт олон улсын сургалт хэлэлцүүлгийг 2014 оны 12-р сарын 11-12-ны өдрүүдэд зохион байгуулж, 2014 онд гарсан эхийн ноцтой хүндрэл, 0-5 насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийн талаар дүн шинжилгээ хийж хэлэлцлээ. Сургалт хэлэлцүүлэгт ЭХЭМҮТ-н Эх барих, эмэгтэйчүүд, нярайн эмгэг судлалын тасгийн эмч нар, ОХУ-н Буриад улсын Хиагт, Зэдийн районы нэгдсэн эмнэлгийн эмч төлөөлөгчид, Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлгийн шинжээч эмч, нэгдсэн эмнэлгийн ЭЭО, зөвлөх эмч нар, эх барих эмэгтэйчүүдийн эмч, нярайн эмч, сум дунд, сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нар нийт 70 гаруй эмч нар оролцлоо.

Эрүүл мэндийн сайдын 2014 оны 120 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор “Эх, хүүхдэд ээлтэй сум” шалгаруулах болзолт уралдааныг аймгийн хэмжээнд 2 үе шаттайгаар зарлаж, үнэлж дүгнэлээ. Аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсгийн дүгнэлтээр Баянгол, Зүүнбүрэн, Жавхлант сумдад эхний 3 байранд шалгарсан.

#### **2.Хүүхэд залуучуудын талаар:**

“ХДХВ/ДОХ-той тэмцэх өдөр”-ийг тохиолдуулан “Охид,хөвгүүдээ хайрлан хамгаалъя” уриан дор аймгийн Эрүүл мэндийн газар, Боловсролын газар, Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын Сэлэнгэ ОНХХ, Улаан Загалмайн Нийгэмлэгтэй хамтран “ХДХВ/ДОХ-ын халдвараас сэргийлье”, “Гэр бүлийн хүчирхийлэл”, “Үе тэнгийнхний дарамт, шахалт”, “Нөхөн үржихүйн эрүүл мэнд”, “Хүсээгүй жирэмслэлт”, “Үр хөндөлт, түүний сөрөг үр дагавар” зэрэг сургалтууд зохион байгуулж дотуур байрны багш нарыг сургагч багшаар бэлтгэлээ.

“ХДХВ/ДОХ/-ын эсрэг өдрөөр бэлтгэгдсэн сургагч багш нар орон нутагтаа нөлөөллийн сургалтыг зохион байгуулж, тус сургалтанд 647 багш, 333 ажилчид, 3860 сурагч, 1854 эцэг, эхчүүд, 688 төрийн албан хаагчдад буюу нийт 7382 иргэдийг хамруулж мэдээлэл өгсөн байна.

Сэлэнгэ аймгийн хүүхдийн “ШИДЭТ ТОЛИНЫ ГАЙХАМШИГ БА ШИНИЙ ШИНИЙ ЭРЭЛД” харшийн сүлд модны наадам 12-р сарын 30-ны өдөр зохион байгуулж, оны шилдэг хүүхдүүдээ тодрууллаа.

#### **3.Нийгмийн халамжийн үйлчилгээний талаар:**

Тайлант хугацаанд нийгмийн халамжийн тэтгэвэрт 3074 иргэнд 3,812,265,098 төгрөг, нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмжинд 1349 иргэнд 929,989,090 төгрөг, ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламжинд 3202иргэнд 375,048,145 төгрөг, амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламжинд 1010 иргэнд 486,625,504 төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй 625 иргэнд 209,640,300 төгрөгний тусламж хөнгөлөлт үйлчилгээг, эхийн алдар одонтой 8541 эхэд 1,168,920,000 төгрөгийн тусламжийг олголоо. Мөн жирэмсэн, хөхүүл нярай

хүүхэдтэй 2982 эхэд 1,341,002,950 төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 762 иргэнд 72,692,900 төгрөг, алдар цолтой ахмадуудад үзүүлэх хөнгөлөлт тусламжийн үйлчилгээнд 88 иргэнд 93,420,000 мянган төгрөгийг олгосон байна.

#### **4.Боловсролын талаар:**

Боловсролын салбарын удирдах ажилтны сургалтыг 12 дугаар сарын 03, 04-ний өдрүүдэд зохион байгуулж, бага боловсролын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа ажлын ололт, амжилтын тайланг сургууль бүрээр тавиулж, харилцан туршлага судлууллаа. Мөн суурь боловсролын шинэчилсэн хөтөлбөрийн туршилтын явцын талаар танилцуулан, сургуулийн захирал 30, сургалтын менежер 52 нийтдээ 82 хүнийг оролцуулан орон нутгийн төрөлжсөн сургалтаар удирдах ажилтнуудынхаа мэдлэг, чадварыг дээшлүүлэн боловсролын чанарын шинэчлэлийг хэрэгжүүлэх арга зүйд суралцууллаа.

БМДИ-тэй хамтран түүх, нийгмийн ухааны багш нарын мэргэжил дээшлүүлэх 3 өдрийн сургалтыг зохион байгуулж, 53 багшийг оролцуулан мэдлэг, чадварыг нь дээшлүүлэн ажиллалаа.

#### **5.Хөдөлмөр эрхлэлтийн талаар:**

2014 оны 11-р сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэд 852 хүн байсан бол 51 иргэн шинээр бүртгүүлж ажил олгогчоос ирүүлсэн 36 ажлын байранд 36 хүнийг ажилд зуучилж, идэвхигүйн улмаас 46 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 821 болсон байна.

2013-2014 онд “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-т хамрагдсан Баруунбүрэн, Орхонтуул, Сант, Орхон, Сайхан, Алтанбулаг, Шаамар, Ерөө, Жавхлант, Хушаат, Түшиг, Цагааннуур, Зүүнбүрэн зэрэг 13 сумын 65 өрхийн 65 залуу малчин болон сумдын хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд оролцон сургалт, зөвлөгөөн зохион байгууллаа. Зөвлөгөөнд оролцсон малчин өрхүүд өөрсдийн хийсэн бүтээгдэхүүнээрээ сүү цагаан идээ, мөн бусад өрхөд үйлдвэрлэсэн сур суран бүтээгдэгдэхүүн, зөгийн бал, шпрот, даршилсан ногоо, жимс жимсгэнэ, монгол гутал, лоовууз, эмийн ургамал зэрэг бүтээгдэхүүнээр үзэсгэлэн гарган 4.0 сая гаруй төгрөгийн бүтээгдэхүүн борлууллаа.

Мандал суманд Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс болон Буган халиун ажнай морин спорт, уяачдын холбоотой хамтран хурдан морь унадаг 37 хүүхэд болон 15 уяачдыг хамруулан “Хурдан морь унаач хүүхдүүдийн аюулгүй байдал” сэдэвт сургалт зөвлөгөөнийг зохион байгуулан ажиллалаа.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт Сүхбаатар сумын 2 иргэнд 2.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлэн шинээр 2 ажлын байр бий болголоо.

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 3-р сургуулийн 11, 12 ангийн нийт 39 сурагчдад “Мэргэжил бүхэн сайхан” сургалтыг зохион байгууллаа.

#### **6. Нийгмийн даатгалын үйлчилгээний талаар:**

2014 оны 12 сарын 30-ны байдлаар Нийгмийн даатгалын сангуудад 28,6 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл оруулах төлөвлөгөөтэйгээс 22,8 тэрбум төгрөг хуримтлуулж төлөвлөгөөний биелэлт 80 хувьтай байна.

Тэтгэврийн даатгалын сангаас 13782 тэтгэвэр авагчдад 35,4 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын сангаас 5940 даатгуулагчдад 1,8 тэрбум



мянган төгрөгний ХЧТА, жирэмсэн болон амаржсаны, оршуулгын, тэтгэмж, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 382 даатгуулагчид 972,7 мянган төгрөгийн тэтгэвэр, ҮО-ийн тэтгэмж, сувилалын зардал, ЭМД-ын сангаас 9 эмнэлэг 35 эмийн сангаар үйлчлүүлсэн нийт 74027 иргэний эмчилгээ, эмийн үнийн хөнгөлөлтөнд 2,8 тэрбум төгрөг зарцуулжээ.

Ажилгүйдлийн даатгалын сангаас 412 даатгуулагчдад 405,3 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж олголоо.

2014 онд 79 ажил олгогч, шинээр бүртгэж 159 даатгуулагчийг албан журмын даатгуулд хамрууллаа.

Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулинд хамрагдсан 2015 оны 01 сарын 01-нээс тэтгэврээ шинээр тогтоолгох, нэмэгдүүлэх иргэдийн нэмэгдлийг хийж ажиллалаа.

Тэтгэврийн хяналтаар бүрэн тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоосон, хөдөлмөрийн чадвар бүрэн алдсаны нэмэгдлийг тооцоогүй, ЦАХТТТ хуулийн 1.3 дахь заалтыг зөрчиж НДСОТТТ хуулийн 7.1 дэх заалтаар тэтгэвэр тогтоосон, дундаж цалин буруу тооцсон зэргээр тэтгэвэр дутуу олгосон 35 тэтгэвэр авагчдад олгохоор тооцсон **9758257** төгрөгийг бүрэн олгосон. ЦАХТТТ хуулийн 8.2 дахь заалтыг зөрчин эрх үүсэхгүй тэтгэвэр тогтоосон, ажилласан хугацааг илүү тооцсон, тэтгэвэр эхлэж олгох хугацааг буруу тогтоосон зэрэг зөрчилд илэрсэн 17 тэтгэвэр авагчид илүү олгосон 7343,9 мянган төгрөгийн авлагыг бүрэн барагдуулсан.

#### **Тав. Үйлдвэр, хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:**

Сайхан, Хушаат сумдын хөрс хамгаалах чиглэлээр хийсэн ажлын танилцуулгыг аймгийн Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлэхэд бэлэн болгоод байна. Тухайлбал: Сайхан сумын Дэлгэр хавцал ХХК нь сүүлийн 4 жил тэг технологийг нэвтрүүлж, нэгж талбайгаас 12-15 цнбуюу 2700 тн ургац хураан авсан бөгөөд химийн уринш-улаанбуудай-рапс-тэжээлийн ургамал, үр тариа, вандуй гэсэн сэлгээг мөрдөж ажиллаж байна.

Загас аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр батлуулахад бэлэн болгоод байна.

Сэлэнгэ аймгийн цэвэр эрлийз нутгийн шилмэл омгийн малын дүн мэдээг нэгтгэж Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны мал хамгаалах санд хүргүүлсэн. Энэ онд Сэлэнгэ аймагт 337972 мянган толгой цэвэрэрлийз мал өвөлжиж байна.

1650 кг адууны махны 11 дээж, үхрийн 15360 кг махны 96 дээж, хонины 2716 кг махны 97 дээж, ямааны 740 кг махны 37 дээж, гахайн 340 кг махны 5 дээж, сүүний 6 дээжинд МЭАЦ-ийн магадлан шинжилгээ хийж баталгаажуулалт олгов.

Хөрөнгө оруулалтаар ирсэн эм бэлдмэл, ариутгалын бодисын жилийн эцсийн орлого зарлагын тайлан бүртгэлийг хөтөлж, жилийн эцсийн тооллогыг хийж гүйцэтгэлээ.

#### **Зургаа. Газрын харилцаа, барилга хот байгуулалтын чиглэлээр:**

##### **1. Газрын харилцааны талаар:**

Иргэн аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн 3 өргөдөл гомдолд холбогдох хээрийн болон суурин судалгааг хийж хуулийн дагуу шийдвэрлэж хариу өгсөн байна.

“Газрын кадастрын мэдээллийн сан”-г солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд “Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг

засварлах, геодезийн солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх” ажлын явцад Мандал, Сүхбаатар суманд газрын нэгж талбарын хувийн хэргийн бүрдүүлэлтийг хийж ажилласан.

Газрын харилцааны албан хэрэгцээнд ашиглагддаг программ хангамж шинэчлэгдэж “Land Manager” программыг нэвтрүүлэх болсонтой холбоотой 16 суманд газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч нарын бүх мэдээллийг мэдээллийн баазад 354 нэгж талбар хувийн хэргийн мэдээллийг уг праграммд шивж орууллаа.

Баруунбүрэн суманд өмчлөлийн 365, өвөлжөөний 239, төмс хүнсний ногооны зориулалтаар 260, үр тарианы зориулалтаар 214 нэгж талбарын хувийн хэргийн анхан шатны өргөдөл матетриалын бүрдүүлэлтийг хийж нэгж талбарын хувийн хэрэг үүсгэж, өмнөх онуудын газартай холбоотой Засаг даргын захирамжуудыг хувийн хэргийн бүртгэлтэй тулгалт хийн мэдээллийн сангийн бүртгэлийн шивэлтэнд оруулахад бэлэн болгон зөрүүтэй мэдээллийн жагсаалтыг гаргалаа.

Аймгийн Засаг даргын захирамжаар газар өмчилж авсан иргэдээс нийт 22, Алтанбулаг сумын Засаг даргын захирамжаар газар өмчилж авсан нийт 15 иргэнд газар өмчлөлийн материалыг бүрдүүлэн өгч Улсын бүртгэлийн хэлтэст шилжүүлсэн байна.

“Газрын кадастрын мэдээллийн сан”-г солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд “Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх” ажлын хүрээнд Сүхбаатар сумын хэмжээнд газар өмчилж авсан 132 иргэнээс 1005 иргэний кадастрын зургийг ARCGIS программд бүртгэж баталгаажууллаа

## **2.Барилга хот байгуулалтын чиглэлээр:**

Тайлант хугацаанд нийт 12 барилга байгууламжийг байнгын ашиглалтанд хүлээлцүүлэх улсын комиссын хурлыг зохион байгуулан ажиллаж улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа барилга угсралтын 10 ажилд захиалагчийн хяналт хийж ажиллав.

Мандал суманд ТОСК-ын шугамаар хэрэгжиж буй 126 айлын 2 ш 9 давхар барилгынгадна дулаан, цэвэр, бохир ус, холбоо дохиолол, гадна цахилгаан хангамжийн төсөв, Сүхбаатар сумын ПСМК, Залуус хороолол тийш явсан дулааны шугамын төсвийг томсгосон жишиг үнэлгээгээр хийж өгөв.

Эрчим хүчний яамнаас эрх шилжиж ирсэн 9 сумдын ажил, Цагааннуур сумын төвийн шинэчлэлтийн ажил дээр хяналтын төсөв хийлгэх талаар албан тоот хүргүүллээ.

Мандал сумын 1000 тн ногооны зоорь, хүлэмжийн барилга, 100 хүүхдийн цэцэрлэгийн барилга дээр хяналт тавьж ажиллалаа.

Шаамар сумын ШТСтанц, Үйлчилгээний төвийн байр, Баянгол сумын ШТСтанцын барилгууд дээр улсын комисс ажиллаж үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авч, Сүхбаатар сумын 5-р багийн 75 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлын гүйцэтгэлийг гаргаж Боловсролын яаманд хүргүүлсэн.

Мандал сумын 25 ортой Эмнэлэгийн барилгын өргөтгөлийн барилга болон 6 кв-н ХТП-н барилгын ажлын цахилгаан хангамж, монтаж холболтын ажлууд 95 хувьтай, ашиглалтын шаардлагад нийцүүлэн хийх шаардлага өгсөн.

Сүхбаатар сумын Худалдааны төвийн гадна цахилгаан хангамж болох 6 кв-н ЦДАШ-н КТП-н 400 кв чадалтай тр-рын ажлын төсвийг хийж өгсөн.

### **Долоо. Байгаль орчны чиглэлээр:**

Агаарын бохирдол, доройтлыг бууруулах төлөвлөгөөг УЦУОША-тай хамтран боловсруулж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхэд бэлэн болгоод байна.

Байгаль орчны үнэлгээ, аудитад хамрагдах аж ахуй нэгж байгууллагын судалгааг гаргалаа. Аймгийн МХГ-ын хяналт шалгалтаар илэрсэн зөрчилтэй аж ахуй нэгжийг байгаль орчны аудитад хамруулахаар гаргаж, нийт 69 төсөлд байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээ хийсэн.

Аймгийн байгаль орчны салбарын зөвлөгөөнийг 12 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулж, оны шилдгүүдээ тодруулан, 2015 онд баримталж ажиллах бодлого чиглэлээ тодорхойллоо.

### **Найм.Сум орон нутгийн талаар:**

#### **1.Баянгол сум:**

Сумын Засаг даргын 2014 оны А/289 тоот соёл мэдээллийн цагийн арга хэмжээг зохион байгуулах тухай захирамж гарч, ажлын хэсэг томилогдон 2014-2015 онд хэрэгжүүлэх соёл мэдээллийн цаг арга хэмжээг урлаг, спортын төрлөөр явуулах хуваарийг батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна.

Жилийн эцсийн мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн ээлжит тооллогыг зохион байгуулж, нэгдсэн дүнг аймгийн Статистикийн хэлтэст хүргүүллээ.

Гахайн сонгомол мялзан өвчний хорио цээрийн дэглэм буурсантай холбоотой гахайн аж ахуй эрхлэгч иргэдэд гахайгаа байран маллагаанд байлгах тухай мэдэгдэл санамж хүргэн МЭҮН-үүдэд байнгын жижүүрлэн ажилласан. Хорио цээрийн дэглэмийн үед ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн байна.

Тайлант хугацаанд шинээр төрсөн 16, шинээр гэрлэсэн 2, гэрлэлт цуцлуулсан 3, эцэг тогтоосны бүртгэл 4, нас барсан 2, шилжин ирсэн 10, шилжин явсан 13, бүртгэлийг тус тус хийсэн. Иргэний үнэмлэх шинээр 12, сунгалт 6, дахин 8 нийт 26 хэвлэгдэж ирснийг олгосон байна.

#### **2.Жавхлант сум:**

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 9-р хуралдаан 2014оны 12-р сарын 23-ны өдөр хуралдаж, дараах асуудлуудыг хэлэлцэн баталлаа. Үүнд: 2014 оны төсөвт тодотгол хийх тухай, Сумын 2014 оны төсвийн гүйцэтгэл, 2015 оны төсвийн төсөл, Сумын 2014 оны үндсэн чиглэлийн биелэлт, 2015 оны үндсэн чиглэл, 2015 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөө, Сумын хөгжлийн Ерөнхий төлөвлөгөө батлах тухай, Сумын 2014 оны үндсэн чиглэлийн биелэлтийг хангалттай гэж дүгнэн цаашид үндсэн чиглэлд тусгагдсан дутуу хийгдсэн ажлуудыг хийж гүйцэтгэх, 2015 оны үндсэн чиглэлд тусган хийж хэрэгжүүлэхийг сумын Засаг даргад даалгалаа. 2014 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт, 2015 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэлэлцэн иргэдийн хашааны газрын өмчлөх асуудлыг эрчимжүүлэх, бэлчээр, хадлангийн талбайг сэлгэн ашиглах, иргэд аж ахуйн нэгжид жимс жимсгэний талбайг олгох зэрэг асуудлыг хэлэлцэн баталлаа. Мөн сумын 2014- 2030 он хүртэлх Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэлэлцэн баталж, сумын Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх

сангаас зээл олгох, төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсан байна.

“Төрийн албан хаагчдын өдөр”-ийг удирдамжийн дагуу зохион байгууллаа. Төрийн албан хаагчдын баярын өдрөөр төр төсвийн байгууллагын албан хаагчдыг спорт, урлагийн авьяас, хүйсийг харгалзан 5 багт хуваан өрсөлдүүлэв. “Ухаалагтөр- Жавхлантсуманд” зөвлөгөөн болж байгууллага бүр 2014 онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээгээ танилцууллаа.

2014 оны байдлаар Иргэний улсын бүртгэл, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн талаар нийт давхардсан дүнгээр 463 иргэнд төрийн үйлчилгээ үзүүллээ. 2014 онд нийт 104 иргэн үүнээс 16 хүртлэх насны 35 хүүхэд шилжин явсан байна. Шилжин суурьших хөдөлгөөний хувьд /нийслэл хот руу-17, бусад аймагт-72, Сэлэнгэ аймгийн сумдад-15 иргэн/ шилжин явсаныг бүртгэлээс хассан. Мөн 94 иргэн шилжин ирж үүнээс 16 хүртлэх насны 31 хүүхэд бүртгэгдэж шилжин суурьших хөдөлгөөний хувьд /нийслэл хотоос-7, бусад аймгаас-74, Сэлэнгэ аймгийн сумдаас-13 иргэн/ тус тус шилжин ирсэн.

2014 оны жилийн эцэст тоологдсон малын тоо толгойгоор тэмээ-11, адуу - 4457, үхэр 9781, хонь-47789, ямаа-34016 нийт 96054 мал тоологдсон. Урьд онтой харьцуулахад 10 хувиар өссөн байна. Малчин өрх нь 248 бүртгэгдлээ.

### **3.Хушаат сум:**

Сумын хэмжээнд атар газар эзэмшсэний 55 жилийн ой, Ургацын баяр-2014 арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлж, тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдээс шилдгүүдээ шалгаруулж, урамшууллаа.

Сумын жилийн эцсийн мал, тэжээвэр амьтад, худаг, хашааны болон хүн амын тооллогыг төв, хөдөөгийн 8 чиглэлд 28 тоологчтойгоор зохион байгууллаа.

“Архи, тамхигүй сум” аяны хүрээнд зохион байгуулагдаж буй “Архи, тамхигүй хамт олон” уралдааны хүрээнд “Архины хор хөнөөл” сэдэвт сургалтыг зохион байгуулж, 18 иргэнийг хамрууллаа.

Тайлант хугацаанд шинэ төрөлт 4, гэрлэлт 1, эцэг тогтоолт 1, нас баралт 2, баг хооронд шилжсэн хөдөлгөөн 2, өөр аймаг хотоос шилжин ирсэн 3, нийслэл өөр аймаг хот руу шилжсэн 3, шинээр иргэний үнэмлэх олголт 6, цахим үнэмлэхний олголтын бүртгэл 17 нийт 47 бүртгэлийн үйлчилгээ үзүүллээ.

### **4.Хүдэр сум:**

2014 оны жилийн эцсийн хүн ам, мал амьтан тэжээвэр амьтаны тооллого тус суманд 12-р сарын 12-ны өдрөөс эхлэн 10 хоног явагдаж дууслаа. Тооллогоор манай сум 27 мянган мал тоолуулж 2232 хүн тоологдсон байна.

Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө 13234,0 мянган төгрөг гүйцэтгэл 91500,0 хувь 100, аймгийн орлогын төлөвлөгөө 12120.0 гүйцэтгэл 24836,1 хувь 204, улсын төсөвт оруулах орлогын төлөвлөгөө 3639.5 гүйцэтгэл 8760 хувь 240 биелэлтэй байна. Энэ сарын нийт төлөвлөгөө 28993.5 гүйцэтгэл 125096,1 мянган төгрөг хувь 431 биелэлттэй байна. Байгалийн дагалдах баялаг болох самар түүх, ашиглахаар 4 аж ахуй нэгж хүсэлтээ өгснөөс 2 ХХК, 1 хоршоотой гэрээ байгуулсан Орон нутагт самар авч буй аж ахуй нэгж иргэдээс 44150,0 мянган төгрөгийн хураамж авч орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн. Сар бүрийн 5 ны дотор төрийн сангийн төлөөлөгч, сумын засаг даргын орлогчоор хянуулан мэдээ тайланг хүргүүлж байна. Суманд бүртгэлтэй 11 НӨАТ-ч аж ахуй нэгжийн тайланг сар бүрийн 10 ны өдрийн дотор хянаж хүлээн авч ажиллаж байна. Сумын Хэсгийн

төлөөлөгч, БОХУбайцаагч нартай хамтран “ Зэвсэг” хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд бууны албан татвар хурааж, шинээр татвар төлөгчийг бүртгэн ажиллаж байна.

Сумын төсөвт 164134.5 мянган төгрөг төвлөрүүлэхээс 236427,5 мянган төгрөг буюу 143 хувьтай байна.Нийт жилийн эцсийн өссөн дүнгээр орон нутгийн төсвийн төвлөрсөн байгууллагуудад 300545,4 мянган төгрөг, тусгай зориулалтын шилжүүлэгээр төсөвт байгууллагуудад 5984359,3 мянган төгрөгийн санхүүжилт олгоод байна.

Тайлант сард ажил хайгч иргэнээр 5 иргэн бүртгүүлсэн. Ажил хайгч иргэдээс байнгын ажлын байранд 1 иргэнийг зуучилсан.

Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг 16 иргэнд үзүүлсэн байна. Үүнээс 6 даатгуулагчид эрүүл мэндийн дэвтэр нээж, 11 даатгуулагч өөрөө, 5 даатгуулагч улсын төсвөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төлсөн байна. Сайн дурын даатгалд 5 даатгуулагч шинээр даатгуулж, 1 даатгуулагч гэрээгээ цуцалж албан журмын даатгал руу шилжлээ.Нийгмийн даатгалын дэвтэр 7 даатгуулагчид шинээр нээсэн. Мөн албан журмын даатгуулагчдын дэвтрийг баталгаажууллаа. Шинээр 5 даатгуулагчид тэтгэвэр тогтоосноос 2 өндөр насны тэтгэвэр, 3 тахир дутуугийн тэтгэвэр тогтоолгож 1 иргэн тэтгэвэрийн материалаа шинээр өгч Сэлэнгэ аймаг нийгмийн даатгалын хэлтэст хяналтын шатандаа явж байна.

Улсын бүртгэлд бүртгүүлж төрсний гэрчилгээ авсан 4 хүүхэд, үүнээс эцэг тогтоолтоор 2 хүүхэд төрсний гэрчилгээ авсан. Шилжиж ирсэн 3, шилжиж явсан 2, 16 нас хүрсэн, 25, 45 насны сунгалт хийлгэсэн 6, иргэний материалыг хүлээн авч бүртгэн холбогдох газар хүргүүллээ.

#### **5.Орхон сум:**

Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны шуурхай байдлыг хангах, бодлого боловсруулах түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор иргэдэд төр засаг аймаг орон нутгийн цаг үеийн мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулсан. Тайлант хугацаанд төрийн захиргааны албан хаагчид айл өрхөөр явж сум хөгжүүлэх сангийн 2015 оны тэргүүлэх чиглэл, зээлийн хэмжээ, хүү, хугацааг тодорхойлох талаар санал асуулгуудыг авч давхардсан тоогоор нийт 195 өрх иргэнийг хамруулан холбогдох шийдвэрүүдийг гаргаж ажилласан.

Сумын Засаг даргын 2014 оны А/171 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 2014 оны 12 дугаар сарын 07-ны өдрөөс 10 хоногийн хугацаанд зохион байгуулж тооллогын бүрэлдэхүүнд 44 тоологч ажиллаж төвийн багт 3 хэсэг, хөдөөгийн багт 7 бүгд 10 хэсэгт тооллогыг явууллаа. Хүн ам, мал тэжээвэр амьтны тооллогонд нийт 746 өрхийн 2349 хүн тоологдож, 383 малчин, мал бүхий өрхийн нийт 97420 толгой мал тоологдлоо. Сумын хэмжээнд адуу 5013, үхэр 11995, хонь 43300, ямаа 37112 тоологдсоныг програмд шивж бүртгэлжүүлсэн.

Хүн ам, мал тэжээвэр амьтны тооллогонд явж, явсан хэсгийн малын тооллогын дүнг нэгтгэн гаргасан сумын малын тоог программд шивж нэгтгэсэн 2014 оны мал тооллогоор сумын Дүнгээр адуу 5013, үхэр 11995, хонь 43300, ямаа 37112 бүгд 97420 толгой мал тоологдсон дүн гарлаа.

Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд 2014 оны 12 сарын 04-ны өдрийн байдлаар түлшний 1150м/куб, хэрэглээний 80 м/куб модыг иргэд, албан байгууллагууд бэлтгээд байна.

2015 оны Газар зохион байгуулалтын төлөвлөөгөөгөө батлуулахтай холбогдуулан 2015 онд төлөвлөгөөнд оруулах саналыг Шийр, 42-р зөрлөг, сумын төвийн 190 иргэнээс авч Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 49 тоот тогтоолоор батлууллаа.

Нийгмийн даатгалын шимтгэлд 21065,4 мянган төгрөг, сайн дурын даатгалд 40 иргэний 1684,4 мян төгрөг, Эрүүл мэндийн даатгалд 15 иргэний 120,6 мянган өгрөгийг тооцож нийгмийн даатгалын санд оруулав.

#### **6.Орхонтуул сум:**

Сумын Засаг даргын Зөвлөлийн ээлжит хуралдаан энэ сарын 18-ны өдөр хуралдаж 2014 онд ажил, үйлсээрээ манлайлсан

1. Шилдэг төрийн албан хаагч
2. Шилдэг ажилтан
3. Шилдэг байгууллага
4. Шилдэг сурагч
5. Байгууллагын шилдэг ажилтанг шалгаруулах тухай болон шагналын зардлыг хэрхэн шийдвэрлэх тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Шинэ жилийн баярын амралтын өдрүүдэд иргэдийн амар тайван байдлыг хангах, гэмт хэрэг зөрчил болзошгүй аюулаас хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор сумын Засаг даргын “Хариуцлагатай эргүүл, жижүүр томилох тухай” А141 тоот захирамж гаргалаа.

Энэ сард иргэдээс нийт 5 өргөдөл хүсэлт хүлээн авсан бөгөөд үүнээс мал бүхий өрхийн шилжин суурьших тухай хүсэлт-1, өвөлжөөний газар, бэлчээрийн газрын маргаан шийдвэрлүүлэх тухай-2, ажил хүссэн-1, хувийн мал эмнэлэг байгуулах зөвшөөрөл хүсэх тухай-1 өргөдөл ирүүлсэн байна. 96201416 дугаарын нээлттэй утсанд 1 иргэн хандсан бөгөөд сумын халаалтын төвийн үйл ажиллагаатай гомдол ирснийг холбогдох газарт нь хүргэж шийдвэрлүүллээ.

Өвөл цагийн соёл хүмүүжлийн ажлын хүрээнд “Байгууллага сурталчилах 7 хоног арга хэмжээг байгууллага бүр мэдээллийг иргэдэд нээлттэй хүргэх, урлаг, спортын арга хэмжээ, хууль эрх зүйн сургалт сурталчилгаа явуулах гэсэн бүтэцтэйгээр зохион байгуулж байна.

#### **7.Цагааннуур сум:**

2014 оны мал хөдөө аж ахуйн тэжээвэр амьтад, малын тэжээлийн тооллогыг сумын Засаг даргын 2014 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/128 тоот захирамжаар зохион байгууллаа. 2014 оны жилийн эцсийн тооллогоор нийт 138762 мал тооллогдсоноос адуу 4293, үхэр 16619, хонь 69975, ямаа 47875 тус тус тоологдож өнгөрсөн оноос 16922 толгойгоор өссөн байна. Мөн сумын нийт хүн ам 4716, өрх 1301 бүртгэгдээд байна.

ХАБЭА-н салбар хорооны ажлын хэсэг баталсан удирдамжийн дагуу хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа Атартрейд ХХК, Товхонхан ХХКболон төсвийн байгууллагуудаас Соёлын төв,Эрүүлмэндийн төв,Спорт цогцолбор дээр Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн талаар үзлэг, хяналтыг хийж гүйцэтгэлээ.Үзлэг, хяналтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах талаар зөвлөмж өгч ажилласан.

Иргэний бүртгэлд шинэ төрсөн108 бүртгүүлсэн гэр бүл32, гэрлэлт цуцлалт 4, үрчлэлт 2, овог нэр өөрчлөлт 2, эцэг тогтоолт 9, нас баралт 17, аймаг хот дотор

болон аймаг хотоос мөсөн шилжин явсан-188 үүнээс насанд хүрэгч 141, хүүхэд 47, аймаг хотод бүр мөсөн шилжин ирсэн83 үүнээс насанд хүрэгч 60, хүүхэд 23 байна.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР